



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/542

Арвайхээр

Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, аймгийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн а/676 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг даргаас нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх журам”-ын 2.3, 2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ахмад настан, гавьяат барилгачин Л.Төмөрбаатарын гэр бүлд хүнд гарз тохиосон тул 300,000 төгрөг, аймгийн Засаг даргад хандаж тусламж хүсэж өргөдөл ирүүлсэн хүнд өвчний улмаас Улаанбаатар хотод яаралтай хагалгаанд орох шаардлагатай Ж.Тогоотогтох (ЙЮ94021102)-д 300,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламжийг тус тус үзүүлсүгэй.

2.Дээрх зардал 600,000 (зургаан зуун мянга) аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

· 011101146

D:My Doc. Zahiramj. Zasag darga